Сөрөг мэдүүлэг бүрдүүлэх, түүнд үнэлэлт дүгнэлт өгөхдөө хариуцагчийн үйлдвэрлэл, бизнесийн нууцыг хамгаалахтай холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг нь харгалзана.

II/ Хамгаалах хугацаа

Хамгаалах хугацаа нь мэдүүлэг өгсөн өдрөөс хойш 20-оос доошгүй жил, эсвэл патент олгосон өдрөөс хойш 17 жил байна. Мэдүүлэг хянах үйл ажиллагааны улмаас үүссэн саатлыг нөхөх зорилгоор тухайн тохиолдолд патентыг хамгаалах хугацааг сунгаж байхыг аль аль Тал дэмжинэ.

III/ Шилжүүлэн хамгаалах

Энэ Хэлэлцээрийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө тухайн Талын патентын хуулиар патент олгодоггүй зүйлийг агуулсан бүтээгдэхүүнийг дараах нөхцөл бүрдсэн тохиолдолд уг Тал шилжүүлэн хамгаалж болно:

1/ бүтээгдэхүүний патент олгоцоггүй зүйлийг нь энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлж эхэлсний дараа патентлах боломжтой бол;

2/энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө нөгөө Талаас тухайн бүтээгдэхүүнд патент олгосон байвал;

3/ эрхийг шилжүүлэн хамгаалж байгаа Талын нутаг дэвсгэр дээр тухайн бүтээгдэхүүнийг борлуулаагүй байвал,

Дээр дурдсан нөхцөлийг хангаж байгаа бүтээгдэхүүний патент эзэмшигч нь эрхийг шилжүүлэн хамгаалж байгаа Талд патентынхаа хуулбарыг өгөх эрхтэй. Уг Тал нь шилжүүлэн хамгаалж байгаа патент хүчинтэй байх хугацаанд түүний эзэмшигчийн хувьд өөрийн нутаг дэвсгэрт тухайн бүтээгдэхүүнийг хийх, ашиглах болон худалдах эрхийг хязгаарлаж болно.

IV/ Лиценз албадан олгох

Өрсөлдөөний хуулийг зөрчсөн нь шүүхээр тогтоогдвол уг зөрчлийг арилгах зорилгоор, эсвэл үндэсний онцгой

байдал зарласанта* холбогдуулан зөвхөн уг байдал үргэлжлэх хугацаанд патент эзэмшигчийн онцгой эрхийг лиценз албадан олгох замаар аль аль Тал нь хязгаарлаж болно. Аль нэг Талын хуулинд лиценз албадан олгохыг зөвшөөрсөн байвал ийм лицензийг худалдааны хэвийн бус байдлыг аль болохоор арилгах хэлбэрээр олгох бөгөөд дор дурдсаныг харгалзбал зохино;

1/ Албадан олгосон лицензийг ашиглаж байгаа үйлдвэрийн тухайн хэсэг буюу нэр хүнд нь холбогдож байгаа этгээдээс бусад этгээдийн хувьд уг лицензийг онцгойлон эзэмшүүлэхгүй буюу дамжуулан ашиглуулахгүй байх.

2/ Өрсөлдөөний хуулийг зөрчсөн нь шүүхээр тогтоогдвол уг зөрчлийг арилгах зорилгоор лиценз албадан олгосноос бусад тохиолдолд патент эзэмшигчид гаргасан зардлыг нь бүрэн нөхөх хэмжээний шагналыг олговол зохино.

3/ Лиценз албадан олгох болзошгүй тохиолдол бүрт уг тохиолдлын онцлогыг тухай бүр харгалзан үзсэн байна.

4/ Албадан олгосон аливаа лицензийг түүнийг олгоход хүргэсэн нөхцөл байдал арилсан тохиолдолд хүчингүй болгох бөгөөд ингэхдээ патент эзэмшигч болон лиценз хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг харгалзан үзсэн байна. Эдгээр нөхцөл байдал үргэлжилж байгаа эсэхийг патент эзэмшигчийн хүсэлтээр хянаж үзнэ.

5/ Лиценз албадан олгох, түүний хугацааг сунгах болон албадан олгосон лицензийн нөхөн төлбөрийг хийх шийдвэрийг холбогдох дээд байгууллага хянана.

г/ Хагас дамжуулагчийн бичил нарийвчийн холболтын дизайн

I. Хамгаалах зүйл

I/ Аль аль Тал хагас дамжуулагчийн бичил нарийвчийн дотор байрлуулсан холболтын дизайны эх хувийг хамгаална.

Гэхдээ холболтын уг дизайн нь тэмдэглэгдсэн буюу кодтой байж болно.

2/ Аль аль Тал нь холболтын дизайныг бүртгэх, тэмдэглэхтэй нь холбогдуулан түүнийг хамгаалах шаардлага тавьж болно. Холболтын дизайныг бүртгүүлэх шаардлагатай байвал мэдүүлэгч нь дизайныг анх борлуулснаас хойш наад зах нь хоёр жилийн хугацаанд мэдүүлгээ гаргана. Холболтын дизайныг танин мэдэхтэй холбогдсон болон бусад материал хадгалуулахыг шаардаж байгаа Тал нь холболтын дизайныг танин мэдэхэд онц шаардлагагүй нууц буюу өмчлөгдсөн мэдээллийг захируулахыг мэдүүлэгчээс шаардахгүй.

II/ Эрх олж авах

I/ Аль аль Тал нь нөгөө Талын интеграл бүдүүвчийн холболтын дизайны эрх эзэмшигчид дор дурдсаныг хийх буюу хийхийг зөвшөөрөх онцгой эрх олгоно:

A/ холболтын дизайныг хуулбарлан олшруулах;

B/ холболтын дизайныг хагас дамжуулагчийн бичил нарийвч дотор байрлуулах;

B/ холболтын дизайныг байрлуулан хагас дамжуулагчийн бичил нарийвч болон тийм нарийвчийг еэртөө агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, түгээх.

2/ Энэ зүйлийн "в"-ийн Ү-д дурдсан нөхцөлийг холбогдох бага зэргийн өөрчлөлтийн хамт холболтын дизайнд лиценз албадан олгоход хэрэглэнэ.

3/ Тухайн бүдүүвчид хэрэглэгддэг бөгөөд гагцхүү түүний үйлдлийн шаардлагын дагуу зохион бүтээсэн дизайн, тухайн холболтын дизайныг бүтээх үед түүнийг аж үйлдвэрт түгээмэл хэрэглэж байсан дизайныг аль аль Тал нь заавал хамгаалах шаардлагагүй.

4. Аль аль Тал нь өөрийн хууль тогтоомжийн дагуу дор дурдсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлж болно;

А/ холболтын дизайны эх хувийг бэлтгэх явцад уг дизайныг үнэлгээ өгөхөд болон сургалт, шинжилгээний зориулалтаар хуулбарлан олшруулах;

Б/ холболтын хамгаалагдсан дизайныг агуулсан хагас дамжуулагчийн бичил нарийвчийг холболтын дизайны эзэмшигч өөрөө, эсвэл түүний зөвшөөрснөөр худалдсан бол эдгээр нарийвчийг хилээр оруулах, түгээх;

В/ тухайн холболтын дизайныг хамгаалагдсан байсныг мэдээгүй буюу мэдэх үндэслэл байгаагүй гэдгээ баталж байгаа этгээд холболтын дизайныг агуулсан хагас дамжуулагчийн бичил нарийвч болон тийм нарийвчийг агуулсан бүтээгдэхүүнийг мэдэгдэл авах хүртэл хилээр оруулах буюу түгээх. Ингэхдээ мэдэгдэл авах үед бэлэн байсан буюу худалдаж авсан барааны хувьд зөвхөн эдгээр барааг хилээр оруулах буюу түгээх бөгөөд мэдэгдэл авсны дараа борлуулсан зүйл бүрээс зохих хэмжээний шимтгэлийг төлөх үүрэгтэй.

Ш/ Хамгаалах хугацаа

Холболтын дизайныг хамгаалах хугацаа нь анх борлуулсан өдрөөс, шаардлагатай бол түүнийг бүртгэсэн өдрөөс / аль түрүүчийнх нь өдрөөс / хойш 10-аас доошгүй жил байна.

д/ Бүтээгдэхүүний дизайн, загвар

1. Аль аль Тал нь наад зах нь шинэ, өвөрмөц, гоёмсог үзэмжтэй болон мэргэжлийн хүмүүст мэдэгдэхүйц бус байсан бүтээгдэхүүний дизайныг хамгаална. Ийм хамгаалалтыг бүртгэл хийлгэх буюу бусад ёс горим гүйцэтгэсний үндсэн дээр олгож байх болзлыг аль аль Тал тавьж болно. Эдгээр дизайныг хамгаалах хугацаа 10-аас доошгүй жил байна.

II/ Тухайн бүтээгдэхүүний дизайныг бусад этгээд бүтээх, хуулбарлах, ашиглах болон худалдахыг таслан зогсоох эрхийг аль аль Тал нь хамгаалагдсан дизайны эзэмшигчид олгоно.

III/ Өрсөлдөөний хуулийг зөрчсөн нь шүүхээр тогтоогдвол уг зөрчлийг арилгах зорилгоор лиценз албадан олгохоос бусад тохиолдолд аль аль Тал нь бүтээгдэхүүний дизайнд лиценз албадан олгохгүй. Энэ зүйлийн "в"-ийн Ү-д заасан нөхцөл нь зохих өөрчлөлтийн хамт албадан олгох лицензид нэгэн адил хамаарна.

е/ Шударга худалдааны үйл ажиллагаанд харшлах үйлдэл болон худалдааны нууцыг хамгаалах

I/ Худалдааны нууцыг, тэр нь дор дурдсан шинж чанартай мэдээлэл учраас эзэмшигчийнх нь зөвшөөрөлгүйгээр шударга худалдаанд харшлах аргаар задруулах, олж авах, ашиглахыг иргэд, компани, байгууллага таслан зогсоох хууль зүйн хэрэгслийг шударга бус өрсөлдөөний эсрэг хийх хамгаалалтыг Парисын Конвенцийн IO дугаар зүйлд заасны дагуу аль аль Тал нь найдвартай хангах явцаа өөрийн хууль тогтоомжид тусгаж үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно;

I/ мэдээлэл нь биет байдлаараа буюу тодорхой хэлбэрээрээ эсвэл бүрэлдэхүүн хэсгийнхээ нийлбэрээр нийтэд түгээмэл болоогүй буюу түүнийг хялбар аргаар тогтоох боломжгүй байгаа;

2/ мэдээлэл нь нийтэд түгээмэл болоогүй буюу түүнийг хялбар аргаар тогтоох боломжгүй байгаа учраас уг мэдээлэл нь зах зээлд үнэлэгдэж байгаа буюу тийм үнэ цэнтэй байж болзошгүй байгаа;

3/ мэдээллийг нууцлах шаардлагатайнулмаас түүнд ухаалгаар хандах ёстой ахул,

II/ Аль аль Тал нь худалдааны нууцыг хамгаалах хугацааг

хязгаарлахдаа энэ зүйлийн 1-ийн "е"-ийн 2-т дурдсан нөхцөл байдал үргэлжлэх бүх хугацаанд заавал хязгаарлахгүй.

Ш/ Лиценз олгох

Аль аль Тал нь худалдааны нууцын сайн дурын лицензийн талаар хэт хатуу буюу ялгаварлан гадуурхах болзол тавих, эсвэл худалдааны нууцын үнэ цэнийг бууруулахад чиглэсэн болзол тавих зэргээр лицензийг сайн дурын үндсэн дээр авах явдал аливаа саад тотгор учруулахгүй.

ИҮ/ Худалдааны нууцыг засгийн газар ашиглах

1/ Худалдааны нууцыг ашигласны зохих үнийг төлөх нөхцөлтэйгөөр түүний эзэмшигчийнх нь зөвшөөрлөөр ашиглах, эсвэл худалдааны нууц эзэмшигчид уг нууцыг онцгойлон эзэмших хангалттай хугацаа тогтоож өгсөн зэргээс бусад тохиолдолд засгийн газрын үйл ажиллагааг явуулахад худалдааны тухай нууцыг гаргаж өгөхийг шаардаж байгаа Тал нь уг нууцыг засгийн газар буюу худалдааны нууц эзэмшигчээс бусад аливаа этгээд худалдаа, өрсөлдөөнд ашиг хонжоо олох зорилгоор ашиглахгүй байх явдлыг хангана.

2/ Талууд худалдааны нууцыг гуравдагч талд зөвхөн нууц эзэмшигчийн зөвшөөрлөөр, эсвэл засгийн газрын зохих үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хэмжээнд задруулж болно. Аль нэг Тал нь засгийн газрын үйл ажиллагааг явуулах үүднээс худалдааны нууцыг засгийн газрын бус этгээдэд задруулсан байвал уг этгээдтэй нууц хадгалах талаар хэлэлцэн тохирох боломжийг худалдааны нууц эзэмшигчид бололцоотой тохиолдол бүрт олгоно.

3/ Худалдааны нууцыг цаашид задруулахгүй, ашиглуулахгүй байх зорилгоор худалдааны нууц хадгалах талаар түүнийг авч ашиглаж байгаа засгийн газрын бус этгээдтэй хэлэлцэн тохирох боломжийг худалдааны нууц эзэмшигчид олгосон тохиолдолд хүн

амын эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах үүднээс нууцаа гуравдагч этгээдэд задруулахыг нууц эзэмшигчээс аль аль Тал нь шаардаж болно.

ж/ Оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх

I/ Энэ зүйлд дурдсан оюуны өмчийн эрхийг аль аль Тал нь иргэний, эрүүгийн, захиргааны хууль, эсвэл тэдгээрийг хослуулсан аргаар дор дурдсан заалттай нийцүүлж хамгаална. Аль аль Тал нь оюуны өмчийн эрх зөрчих аливаа үйл ажиллагаанаас уг эрхийг хамгаалах үр ашигтай арга ажиллагааг нутаг дэвсгэрийнхээ гүнд болон хил дээрээ бий болгох бөгөөд зөрчлийг гаргахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох болон цаашид гарч болзошгүй зөрчлөөс найдвартай урьдчилан сэргийлэх үр ашигтай хэрэгслээр хангана. Уг арга ажиллагааг хууль ёсны худалдаанд саад тотгор үүсгэхгүй байх, энэ ажиллагааг хортойгоор ашиглах явдлын эсрэг хамгаалалт бий болгох хэлбэрээр хэрэгжүүлнэ.

II/ Оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга ажиллагаа нь шударга бөгөөд эрх тэгш байна.

III/ Хэргийн мөн чанарын талаарх шийдвэрийг гол төлөв бичгээр, үндэслэлтэй гаргана. Эдгээр шийдвэрийг мэдэгдэхдээ наад зах нь маргаанд оролцогч талуудад үндэслэлгүй саатал учруулахгүй байвал зохино.

IV/ Оюуны өмчийг хамгаалахтай холбогдсон хэргийн мөн чанарын талаарх захиргааны эцсийн шийдвэрийг шүүхийн журмаар дахин хянах боломжийг аль аль Тал хангана. Хэргийн ач холбогдлын тухай үндэсний хууль тогтоомж дахь хэргийн харьяаллын заалтыг харгалзан оюуны өмчийн эрхийг хамгаалахтай холбогдсон хэргийн мөн чанарын талаарх шүүхийн анхны шийдвэрийн эрх зүйн асуудлыг шүүхээр дахин хянах боломжийг мөн хангана.

Ү/ Нөгөө Талын эсрэг авах арга хэмжээ

Энэ зүйлийн бусад заалтыг үл харгалзан, оюуны өмчийн эрхийг засгийн газар ашигласан буюу засгийн газарт зориулан ашигласны улмаас уг эрх зөрчигдөж үүнтэй холбогдуулан аль нэг Тал нэхэмжлэл гаргавал нөгөө Тал засгийн газрынх нь эсрэг авах арга хэмжээг эрх эдлэгчид хохирлыг бүрэн нөхөн төлөх хэлбэрээр хязгаарлаж болно.

3. Аль аль Тал нь энэ зүйлд дурдсан үүргийг биелүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг 1992 оны 12 дугаар сарын 31-ний өдөр багтаан батлуулахаар оруулах болон уг хууль тогтоомжийг дээр дурдсан хугацаанд батлуулж мөрдөх талаар дээд зэргийн хүчин чармайлт гаргахаар тохиролцов.

4. Энэхүү Хэлэлцээрт:

а/ "эрх эдлэгч" гэж эрх эдлэгчийг өөрийг нь, эсвэл түүний эрх олгосноор эрхийг онцгойлон эзэмшигч хувь хүн, хуулийн этгээд, эсвэл үндэсний хууль тогтоомжийн дагуу уг эрхийг олж авах хууль ёсны эрх олгогдсон бусад этгээд, түүний дотор федераци, ассоциацийг нэрлэнэ.

б/ "шударга худалдааны зарчимд харшлах арга үйлдэл" гэж тухайлбал, хулгай хийх, хээл хажууль авах, өгөх, контракт зөрчих явдал рүү түлхэх, электроникийн болон бусад хэлбэрээр худалдааны тагнуул хийх арга үйлдэл, түүнчлэн худалдааны нууцыг олж авахтай холбогдуулан дээрх арга үйлдэл байсныг мэдсэн буюу мэдэх үндэслэлтэй байсан гуравдагч тал худалдааны нууцыг олж авахыг хэлнэ.

А Р А Э Д У Г А А Р Э У И Л

ЭДИЙН ЗАСАГ, ТЕХНИКИЙН ЦААШИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

1. Хоёр талын худалдааг цаашид хөгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний солилцооны тогтвортой өсөлтийг хамгах зорилгоор татвар болон хөрөнгө оруулалтын асууллаар, түүний дотор ашгийг улс орондоо нилжүүлэх, мөн хэзэнийг гадаадад гүйвүүлэх асууллаар харилцан хүлээн авахуйц хэлэлцээр байгуулахыг хоёр Тал эрмэлзэнэ.

2. Талууд харилцан сонирхсон бүхий л салбарт, түүний дотор статистик, стандартын салбарт эдийн засаг, техникийн хамтын ажиллагааг аль болохоор өргөжүүлэх явдлыг хөхүүлэн цэмжихэд чиглэсэн шаардлагатай алхмыг хийнэ.

3. Үйлчилгээний салбарын өсч байгаа эдийн засгийн ач холбогчдыг Талууд анхааралдаа авч, зах зээлд гарах, түүнийг чөлөөтэй болгох бололцоог аль болохоор нэмэгдүүлэх зэрэг зорилгоор хоёр орны хооронд үйлчилгээний үйл ажиллагаа явуулах, тухайлбал, хувийн үйлчилгээний салбарт харилцан сонирхож байгаа асууллаар зөвлөлдөж бэлгээр тохиролцов.

А Р В А Н Н Э Г Д Ү Г Э Э Р З Ү Й Л

ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭВИЙН БУС БАЙДЛААС ХАМГААЛАХ

1. Нөгөө Талын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй бүтээгдэхүүний одоогийн болон цаашдын импорт нь зах зээлийн хэвийн бус байдлыг бий болгож байгаа буюу түүнд хүргэх шинжтэй байгаа, эсвэл ийм байдлыг бий болгоход ихээхэн нөлөөлж байгаа тохиолдолд Талууд аль нэгнийхээ хүсэлтээр яаралтай зөвлөлдөж байхаар тохиролцов. Дотоодын аж үйлдвэрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй өрсөлдөж болохуйц эсвэл шууд өрсөлддөг бүтээгдэхүүний импорт нь туйлын хэмжээгээр эсвэл харьцангуйгаар түргэн өсч улмаар дотоодын аж үйлдвэрт ихээхэн материаллаг хохирол учруулж байгаа, эсвэл учруулж болзошгүй үед дотоодын аж үйлдвэрт зах зээлийн хэвийн бус байдал бий болно.

2. Энэ зүйлийн I-д заасны дагуу зөвлөлдөх зорилго нь а/ зах зээлийн хэвийн бус байдлыг бий болгож байгаа буюу түүнд хүргэх шинжтэй байгаа, эсвэл ийм байдлыг бий болгоход ихээхэн нөлөөлж байгаа импорттой холбогдсон хүчин зүйлсийг мэдээлэх, судлан шинжлэх, б/ зах зээлийн хэвийн бус байдал гаргахгүй байх болон түүнээс урьдчилан сэргийлэх аргыг эрж хайхад оршино. Талууд өөрөөр тохиролцоогүй бол тийнхүү зөвлөлдөх явдлыг санал болгосон өдрөөс хойш 60 хоногийн дотор гүйцэтгэнэ.

3. Зөвлөлдөх явцад санал зөрүүтэй шийдвэрийн талаар харилцан тохиролцож чадаагүй бол импортлогч Тал нь а/ импортын тоо хэмжээг хязгаарлах, тарифын арга хэмжээ авах зэрэг зах зээлд учирч болзошгүй хэвийн бус байдлаас урьдчилан сэргийлэх, бий болсон хэвийн бус байдлыг

арилгахад аль шаардлагатай гэж үзсэн бусад хязгаарлал тогтоох буюу арга хэмжээ авах, б/ нөгөө Талын нутаг дэвсгэрээс импортлож байгаа бүтээгдэхүүн нь дээрх тоо хэмжээний болон бусад хязгаарлалтад нийцэж байх явдлыг хангах арга хэмжээ авч болно. Энэ тохиолдолд аль болох тэнцвэртэй худалдаа хийх талаар энэхүү Хөлөлцөөрээр хүлээсэн үүргээсээ нөгөө Тал нь чөлөөтэй татгалзаж болно.

4. Импортлогч Тал зах зээлийн ийм хэвийн бус байдал бий болохоос урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах онцгой арга хэмжээ авах шаардлагатай гэж шийдвэл эдгээр арга хэмжээг урьдчилан зөвлөлдөхгүйгээр хэдийд ч авч болох бөгөөд энэ талаар зөвлөлдөхийг нэн даруй санал болгоно.

5. Зах зээлийн хэвийн бус байдлыг тодорхойлдог дотоодын журам нь ил тод байж ийм байдалд өртөгдсөн талуудад үзэл бодлоо илэрхийлэх бололцоо олгохуйц байх явдлыг аль аль Тал хангана.

6. Зах зээлийг хэвийн бус байдлаас хамгаалах тухай энэ зүйлийг ийнхүү дэлгэрэнгүй тохиролцсон нь нэхмэл бөс бараа, түүгээр хийсэн бүтээгдэхүүний худалдаа, шударга бус худалдаа, түүний дотор демпингийн эсрэг болон тэгшитгэх татварын талаарх хууль, дүрмээ хэрэглэх аль аль Талын эрхийг хөндөхгүй гэдгийг Талууд хүлээн зөвшөөрч байна.

А Р В А Н Х О Ё Р Д У Г А А Р З У И Л

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

1. Аль аль Талын иргэд, компани, байгууллага нь нэхэмжлэгч, хариуцагч болон бусад хэлбэрээр нөгөө Талын нутаг дэвсгэр дээрх аливаа шүүх, захиргааны байгууллагад хандахад тэдгээрт үндэсний нөхцөл олгоно. Тэдгээр нь хариуцагч байхаас болон шүүхийн шийдвэр биелүүлэхээс татгалзах, арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхтэй холбогдсон ажиллагаанаас татгалзах, эсвэл худалдааны үйл ажиллагаатай холбогддуулан нөгөө Талын нутаг дэвсгэр дээр хүлээсэн бусад үүргээсээ татгалзах дархан эрх шаардахгүй бөгөөд уг эрхийг эдлэхгүй. Хэрэв хоёр талын бусад хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол тэдгээр нь худалдааны үйл ажиллагаатай холбогдсон татвараас чөлөөлөгдөх дархан эрх шаардахгүй бөгөөд уг эрхийг эдлэхгүй.

2. Бүгд Найрамдах Монгол Ардын Улсын иргэд, байгууллага болон Америкийн Нэгдсэн Улсын иргэд, компанийн хооронд байгуулсан худалдааны гэрээ, хэлцлээс үүдэн гарах маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлж байхыг Талууд дэмжинэ. Маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлж байх талаар эшгээр иргэд, компани, байгууллага харилцан тохиролцсоны үндсэн дээр контрактад, эсвэл тэдгээрийн хооронд бичгээр байгуулсан жич хэлэлцээрт тусгаж болно.

3. Маргааныг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн арбитрын аливаа дүрэм, түүний дотор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон Улсын Худалдааны Эрхийн Комисс /ЮНСИТРАЛ/-ын Дүрмийн дагуу арбитрын журмаар шийдвэрлэж байхаар талууд тохиролцож болно. Энэ тохиолдолд талууд дээрх дүрмийн дагуу арбитрыг томилж эрх бүхий этгээдийг

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, эсвэл Америкийн Нэгдсэн Улсаас өөр гуравдагч орноос сонгоно.

4. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитр хуралцах газрыг Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай 1953 оны Нью-Йоркийн Конвенцийн гилүүн Бүгд Найрамдах Монгол Ард Улс, эсвэл Америкийн Нэгдсэн Улсаас өөр гуравдагч орон байхаар талууд сонгоно.

5. Өөрсдийнх нь онцгой шаардлагад илүү тохиромжтой гэж талууд зөвшөөрөлцөн сонгон авсан арбитрын болон маргаан шийдвэрлэх аливаа хэлбэрийг хэрэглэхээр тохиролцохыг Талууд хориглохгүй бөгөөд Хэлэлцээрийн энэ зүйлийг энэ талаар аливаа хориг тавьж байгаа гэж тайлбарлахгүй.

6. Аль аль Тал арбитрын шийдвэрийг өөрийн нутаг дэвсгэр дээр хүлээн зөвшөөрөх, биелүүлэх найдвартай баталгааг хангана.

А Р В А Н Г У Р А В Д У Г Л А Р З У И Л

ҮНДЭСНЭ, АЖУЛГУЙ, БАЙДАМ

Энэхүү Хэлэлцээрийн заалтууд нь ажулгүй байлдны талаарх өөрсдийн эрх алгийг хамгаалах аливаа үйл ажиллагаа явуулах аль аль Талын эрхийг хязгаарлахгүй.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

ЗӨВЛӨДӨХ

1. Энэхүү Хэлэлцээрийн биелэлтийг Талууд үе үе хянан үзэж зөвлөлдөж байхаар тохиролцов.

2. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, биелүүлэхтэй хойбогдсон асуудал болон Талуудын хоорондын харилцааны бусад асуудлыг хэлэлцэх зорилгоор Талууд аль нэгнийхээ хүсэлтээр зохих шугамаар нэн даруй зөвлөлдөж байхаар тохиролцов.

А Р В А Н Т А В Д У Г А А Р З У Й Л

НЭР ТОМЬЁО

Энэхүү Хэлэлцээрт хэрэглэсэн нэр томьёо дараах агуулгатай байна:

а/ "компани" гэж мөнгөн ашиг олохын тулд байгуулагдсан уу, хувийнх уу, засгийн газрынх уу гэдгийг үл харгалзан, аль нэгэн Талын хууль, журмын дагуу байгуулагдсан аливаа корпораци, компани, ассоциаци, ганц этгээдийн өмчлөлд байгаа болон бусад байгууллага, тэдгээрийн орон нутгийн нэгжийг нэрлэнэ. Аль нэгэн компанийг гуравдагч орны иргэн хянаж байгаа, эсвэл аль нэгэн Талын компани нөгөө Талын нутаг дэвсгэр дээр бизнесийн мэдэгдэхүйц үйл ажиллагаа явуулахгүй байгаа, эсвэл энэ компанийг гуравдагч орны иргэн хянаж байгаа бөгөөд татгалзагч улс уг гуравдагч оронтой эдийн засгийн хэвийн харилцаагүй бол аль аль Тал нь энэхүү Хэлэлцээрийн давуутай нөхцөлийг аливаа ийм компанид олгохоос татгалзах эрхтэй байна;

б/ " худалдааны байгууллагын төлөөлөгчийн газар " гэж аль нэг Талын компани буюу байгууллагын төлөөлөгчийн газрыг нэрлэнэ;

в/ "иргэн" гэж аль нэг Талын мөрдөж байгаа хуулийн дагуу уг Талын иргэн болох хувь хүнийг нэрлэнэ;

г/ "байгууллага" гэж хувийн, эсвэл засгийн газрын өмчлөлд байгаа эсэхийг үл харгалзан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хувьд эдийн засгийн аливаа байгууллага, үйлдвэр/компанийг оролцуулан /-ийг, Америкийн Нэгдсэн Улсын хувьд компанийг тус тус нэрлэнэ.

А Р В А Н З У Р Г А Д У Г А А Р З У Й Л

ХЭЛЭЛЦЭЭРИЙН ЗААЛТЫГ ХЭРЭГЛЭХГҮЙ
БАЙХ ҮНДСЭН ТОХИОЛДОЛ

1. Ижил нөхцөл байдалтай орнуудыг үндэслэлгүйгээр, эсвэл дур зоргоороо ялгаварлан гадуурхах хэрэгсэл бий болгох, эсвэл олон улсын худалдаанд лалдлагдсан хязгаарлал тогтоох үүднээс дор дурдсан арга хэмжээг хэрэглэхгүй байх нөхцлийг баримталсан тохиолдолд аль аль Тал нь эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлж болохгүй гэж энэхүү Хэлэлцээрийн аливаа заалтыг тайлбарлахгүй;

а/ энэхүү Хэлэлцээрийн зорилгод харшлахгүй хууль, журмыг баримтлах явдлыг хангахад шаардагдах арга хэмжээ;

б/ энэхүү Хэлэлцээрийн есдүгээр зүйлд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах, хуурамч ажиллагааг гаргахгүй байх арга хэмжээ;

в/ ГАТТ-ын хорьдугаар зүйлд заасан аливаа бусад арга хэмжээ.

2. Нэхмэл бөс бараа, түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг худалдах тухай Талуудын хооронд мөрдөж байгаа, эсвэл цаашид байгуулж болох аливаа хэлэлцээрийг хэрэглэх явдлыг энэхүү Хэлэлцээр хязгаарлахгүй болно.

3. Нэлээд хэмжээгээр нөгөө Талын Засгийн газрын өмчлөлд, эсвэл түүний нөлөө бүхий хяналтад байдаг байгууллагын талаарх хууль тогтоомжоо аль аль Тал нь хэрэглэхэд энэхүү Хэлэлцээр хориг болохгүй.

А Р В А Н Д О Л Д У Г А А Р З Ү Й Л

ХЭЛЭЛЦЭЭР ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ХҮЧИНТЭЙ БАЙХ ХУГАЦАА, ТҮҮНИЙГ ТҮР ЗОГСООХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

1. Энэхүү Хэлэлцээр /түүний салшгүй хэсэг болох солилцсон захидлуудыг оролцуулан/ нь түүнийг хоёр Засгийн газар хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдлийг бичгээр солилцсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд энэ зүйлийн 2,3-д заасны дагуу хүчин төгөлдөр хэвээр байна.

2.а/ Энэхүү Хэлэлцээр энэ заалтын "б", "в"-д зааснаар эхний 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

б/ Хэрэв аль нэг Тал нь энэхүү Хэлэлцээрээр хүлээсэн аливаа үүргээ биелүүлэхэд дотоодын хууль тогтоомжийн дагуу хууль ёсны эрхтэй эсэх хүндрэлтэй тулгарч байгаа, эсвэл энэ хүндрэлийг урьдчилан мэдэж байгаа бол яаралтай зөвлөлдөхийг нөгөө Талдаа хүсэлт болгоно. Зөвлөлдөх талаар нэгэнт хүсэлт тавьсан бол нөгөө Тал нь "в"-д дурдсан байдлыг бий болгохгүй байх арга зам олохыг зорин, хүсэлт тавьсан Талтай үүссэн нөхцөл байдлын талаар аль болох богино хугацаанд зөвлөлдөнө.

в/ Аль нэг Тал нь энэхүү Хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд дотоодын хууль тогтоомжийн дагуу хууль ёсны эрхгүй бол аль аль Тал нь энэхүү Хэлэлцээрийг бүхэлд нь, эсвэл нөгөө Талтайгаа тохиролцсоны үндсэн дээр түүний аливаа хэсгийг мөрдөхөө түр зогсоож болно. Энэ тохиолдолд Талууд хоёр орны хоорондын худалдааны харилцаанд үүссэн хэвийн бус байдлыг бололцоонхоо хэрээр болон үндэснийхээ хууль тогтоомжид нийцэхүйцээр арилгахыг эрмэлзэнэ.

3. Хэрэв аль нэг Тал нь энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухайгаа Хэлэлцээр хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө нөгөө Талдаа бичгээр мэдэгдээгүй бол

энэхүү Хэлэлцээр нь цаашид гурван жилээр аяндаа сунгагдана.

Хэлэлцээрийг Вашингтон хотноо 1991 оны нэгдүгээр сарын 23-ны өдөр англи, монгол хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн болно. Эх хувиудыг тайлбарлахад санал зөрвөл англи хэл дээрхи эх хувийг баримтлана.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС



THE UNITED STATES TRADE REPRESENTATIVE

WASHINGTON

20506

January 23, 1991

Dear Mr. Minister:

In connection with the signing on this date of the Agreement on Trade Relations Between the Government of the United States of America and the Government of the Mongolian People's Republic (the "Agreement"), I have the honor to confirm the understanding reached by our Governments (the "Parties") regarding the establishment of commercial representations in the Mongolian People's Republic as follows:

The Government of the Mongolian People's Republic intends to liberalize the procedure to establish a commercial representation. Pending a formal change in applicable legislation, the Government of the Mongolian People's Republic intends to administer the procedure as a simple registration process.

I have the further honor to propose that this understanding be treated as an integral part of the Agreement on Trade Relations. I would be grateful if you would confirm that this understanding is shared by your Government.

Sincerely,



Carla A. Hills

The Honorable Sed-Ochiryn Bayarbaatar
Minister of Trade and Industry
Mongolian People's Republic

ЭРХЭМСЭГ ХАТАГТАЙ ЭЛЧИН САЙД АА

Танаас дараах агуулга бүхий захидал хүлээн авснаа нотлох завшаан олдлоо:

"Эрхэмсэг ноён Сайд аа

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар худалдааны байгууллагын төлөөлөгчийн газар байгуулах журмыг хөнгөвчлөхийг эрмэлзэнэ. Мөрдөж байгаа хууль тогтоомжид албан ёсны өөрчлөлт оруулах хүртлээ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар дээрх журмыг ердийн бүртгэлийн хэлбэрээр хэрэглэнэ.

Ийнхүү ойлголцсоныг худалдааны харилцааны тухай Хэлэлцээрийн салшгүй хэсэг болгон авч үзэхийг санал болгох завшаан дахин олдлоо. Үүнийг танай Засгийн газар хүлээн зөвшөөрч байгааг Та нотолбол би талархах болно",

Дээр дурдсаныг манай Засгийн газар хүлээн зөвшөөрч байгааг болон ийнхүү ойлголцсоныг Хэлэлцээрийн салшгүй хэсэг мөн болохыг батлах завшаан дахин олдлоо.

Таныг хүндэтгэсэн



Сэд-Очирын Баярбаатар
БНМАУ-ын Худалдаа, үйлдвэрийн
сайд

АНУ-ын Худалдааны
төлөөлөгчийн газрын
Элчин сайд
Эрхэм хүндэт Карла А.Хиллс
Танаа

THE UNITED STATES TRADE REPRESENTATIVE
WASHINGTON
20506

January 23, 1991

Dear Mr. Minister:

I have the honor to acknowledge receipt of your letter of today's date concerning benefits under the Generalized System of Preferences ("GSP") which reads as follows:

During the course of the negotiation of the Agreement on Trade Relations Between the Government of the United States of America and the Government of the Mongolian People's Republic, the delegation of the Government of the Mongolian People's Republic requested that the Government of the United States of America accord benefits to products of the Mongolian People's Republic under the Generalized System of Preferences.

I wish to reiterate this request and ask that your government give it due consideration.

Please be assured that the Government of the United States will give your request due consideration. In this regard, we trust that the explanation provided by the U.S. delegation concerning the eligibility requirements for GSP were useful to your delegation.

Sincerely,



Carla A. Hills


The Honorable Sed-Ochiryn Bayarbaatar
Minister of Trade and Industry
Mongolian People's Republic

ЭРХЭМСЭГ ХАТАГТАЙ ЭЛЧИН САЙД АА

Худалдааны харилцааны тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийн талаар хийсэн хэлэлцээний үед Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын төлөөлөгчид Преференцийн ерөнхий системийн дагуу олгодог хөнгөлөлтийг Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газраас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бүтээгдэхүүнд олгохыг хүсэлт болгов.

Энэ хүсэлтээ дахин тавьж түүнийг танай Засгийн газар зохих ёсоор анхаарч үзэхийг хүсч байна.

Таныг хүндэтгэсэн



Сэд-Очирын Баярбаатар
БНМАУ-ын Худалдаа, үйлдвэрийн
сайд

АНУ-ын Худалдааны
төлөөлөгчийн газрын
Элчин сайд
Эрхэм хүндэт Карла А.Хиллс
Танаа



UNITED STATES DEPARTMENT OF COMMERCE
The Under Secretary for Travel and Tourism
Washington, D.C. 20230

Washington, January 23, 1991

Dear Mr. Minister:

In connection with the signing on this date of the Agreement on Trade Relations Between the Government of the United States of America and the Government of the Mongolian People's Republic (the "Agreement"), I have the honor to confirm the understanding reached by our Governments (the "Parties") regarding cooperation in the field of tourism services as follows:

The Parties recognize the need to encourage and promote the growth of tourism and travel-related investment and trade between the United States of America and the Mongolian People's Republic.

The Parties recognize the benefits to both economies of increased tourism and travel-related investment in and trade between their two territories.

Each Party shall seek permission of the other Party prior to the establishment of official, governmental tourism promotion offices in the other's territory. Permission to open official tourism promotion offices or field offices shall be as agreed upon by the Parties, and subject to the applicable laws, regulations and policies of the host country. Official tourism promotion offices opened by either Party shall be operated on a non-commercial basis. Official tourism promotion offices and the personnel assigned to them shall not function as agents or principals in commercial transactions, enter into contractual agreements on behalf of commercial organizations or engage in other commercial activities. Such offices shall not sell services to the public or otherwise compete with private sector travel agents or tour operators of the host country. Nothing in this side letter shall obligate either Party to open such offices in the territory of the other.

Private and governmentally-owned commercial tourism enterprises shall be treated as private commercial enterprises fully subject to all applicable laws and regulations of the host country.

The Honorable Sed-Ochiryn Bayarbaatar
Minister of Trade and Industry
Mongolian People's Republic

Each Party shall ensure, within the scope of its legal authority, that any company owned, controlled or administered by that Party, or any joint venture therewith, which effectively controls a significant portion of the supply of any tourism or travel-related service in the territory of that Party shall provide those services to nationals and companies of the other Party in a fair and equitable manner and on a most-favored-nation basis.

Nothing in this letter or in the Agreement shall be construed to mean that tourism and travel-related services shall not receive the benefits from that Agreement as fully as all other industries and sectors.

The Parties will consider negotiating a separate agreement on tourism and travel-related services.

I have the further honor to propose that this understanding be treated as an integral part of the Agreement. I would be grateful if you would confirm that this understanding is shared by your Government.

Sincerely,

A handwritten signature in cursive script, appearing to read "R. A. Schnabel".

Rockwell A. Schnabel



ЭРХЭМСЭГ НОЁН ОРЛОГЧ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА АА

Танаас дараах агуулга бүхий захидал хүлээж авснаа нотлох завшаан олдлоо. Үүнд:

" Эрхэмсэг ноён Сайд аа

Худалдааны харилцааны тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр /" Хэлэлцээр " /-т өнөөдөр гарын үсэг зурсантай холбогдуулан жуулчлалын үйлчилгээний салбарт хамтран ажиллах талаар манай Засгийн газрууд /" Талууд " /-ын хооронд дор дурдсан зүйлийг харилцан ойлголцсоныг батлах завшаан олдлоо:

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Америкийн Нэгдсэн Улсын хооронд жуулчлал болон аялалтай холбогдсон хөрөнгө оруулалт, худалдааг нэмэгдүүлэх явдлыг хөхүүлэн дэмжих шаардлагатай байгааг Талууд хүлээн зөвшөөрч байна.

Талуудын нутаг дэвсгэр дээр жуулчлал болон аялалтай холбогдсон хөрөнгө оруулалт, худалдааг нэмэгдүүлэх нь хоёр улсын эдийн засагт ашигтай болохыг Талууд хүлээн зөвшөөрч байна.

Тал тус бүр нөгөө Талын нутаг дэвсгэр дээр жуулчлалыг хөхүүлэн дэмжих засгийн газрын албан ёсны төлөөлөгчийн газар байгуулахын өмнө нөгөө Талын зөвшөөрлийг авна. Жуулчлалыг хөхүүлэн дэмжих албан ёсны төлөөлөгчийн газар, эсвэл түүний салбарыг нээх зөвшөөрлийг Талууд хүлээн авч байгаа орны мөрдөж буй хууль дүрэм, бодлогыг харгалзан тохиролцон гаргана. Талуудын жуулчлалыг хөхүүлэн дэмжих албан ёсны төлөөлөгчийн газар нь худалдааны бус үндсэн дээр ажиллана. Жуулчлалыг хөхүүлэн дэмжих албан ёсны төлөөлөгчийн газар, тэдгээрийн ажилтнууд нь худалдааны үйл ажиллагаанд төлөөлөх, оролцох болон худалдааны байгууллагуудын нэрийн өмнөөс контракт

АНУ-ын Худалдааны яамны
Орлогч нарийн бичгийн дарга
Эрхэм хүндэт Роквелл А.Шнаебел
Танаа

байгуулах зэргээр худалдааны үйл ажиллагаанд оролцохгүй. Эдгээр төлөөлөгчийн газар нь нийтэд төлбөртэй үйлчилгээ үзүүлэх болон бусад хэлбэрээр хүлээн авч байгаа орны аялал, жуулчлалын хувийн байгууллагын төлөөлөгч буюу аялал зохион байгуулагч нартай өрсөлдөхгүй. Энэхүү захидлаар аль нэгэн Тал нөгөө Талын нутаг дэвсгэр дээр эдгээр төлөөлөгчийн газрыг заавал байгуулах үүрэг аваагүй болно.

Хувийн болон засгийн газрын өмчлөлд байгаа жуулчлалын худалдааны байгууллага нь хүлээн авагч байгаа орны хууль дүрмийг даган мөрдөх бөгөөд тэдгээрийг хувийн худалдааны байгууллага гэж үзнэ.

Өөрийн эзэмшил, хяналт, удирдлага дор байдаг аливаа компани болон нутаг дэвсгэрт нь жуулчлал, аялалтай холбогдсон үйлчилгээний дийлэнх хэсгийг хянадаг аливаа хамтарсан үйлдвэрээс эдгээр үйлчилгээг нөгөө Талын иргэд, компанид шударга, эрх тэгш хэлбэрээр болон нэн тааламжтай үндэстний нөхцөлийн үндсэн дээр үзүүлж байх явдлыг хууль ёсны эрх хэмжээнийхээ хүрээнд аль аль Тал нь хангана.

Энэхүү Хэлэлцээрт заасан таатай нөхцөлийг бусад салбаруудад олгодог хэмжээгээр жуулчлал, аялалтай холбогдсон үйлчилгээнд хамааруулахгүй гэж энэ захидал болон Хэлэлцээрийг тайлбарлахгүй.


Талууд жуулчлал, аялалтай холбогдсон үйлчилгээний тухай жич хэлэлцээр байгуулах талаар хэлэлцээ хийх явдлыг анхаарны.

Ийнхүү ойлголцсоныг Хэлэлцээрийн салшгүй хэсэг болгон авч үзэхийг санал болгох завшаан дахин олдлоо. Үүнийг танай Засгийн газар хүлээн зөвшөөрч байгааг Та нотолбол би талархах болно".

3.

Дээр дурдсаныг манай Засгийн газар хүлээн зөвшөөрч байгааг болон энэхүү захидал Хэлэлцээрийн салшгүй хэсэг мөн болохыг батлах завшаан дахин олдлоо.

Таныг хүндэтгэсэн



Сэд-Очирын Баярбаатар

БНМАУ-ын Худалдаа, үйлдвэрийн яам